



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 40

Арвайхээр

Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 -ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Соёлын үйлдвэрлэл” аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсгэврийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Орон нутагт онцлог соёл, урлагийн үйлчилгээ, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл боломжийг бий болгон, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
40 дүгээр тогтоолын Нэгдүгээр хавсралт

“СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэгүндэслэл

1.1. Монгол улсын Засгийн газрын 2015 оны 509 дүгээр тогтоолоор баталсан “Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр”, Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын 4.1.8-д “соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, соёлын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, соёл, урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбар хоорондын уялдаа, холбоог сайжруулах”, Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 4.2.6.1-д “үндэсний түүх, өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, мэдлэг, мэдээлэлд суурилсан бүтээлч аж үйлдвэрийн салбарыг дэвшилтэт техник технологи, инновацид тулгуурлан мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар хөгжүүлж, шинэ чадавхи, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох” хэмээн тус тус заасан.

1.2. Соёлын үйлдвэрлэлийг олон улсын туршлагаас харахад “соёлын үйлдвэрлэл”, “бүтээлч үйлдвэрлэл”, “соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэл”, “чөлөөт цагт зориулсан үйлдвэрлэл” зэргээр нэршин томъёолж байгаа ч дэлхий нийтэд эдгээрийн талаарх нэгдсэн нэг ойлголт, албан ёсны тодорхойлолтод хүрээгүй байгаа бөгөөд улс орнууд өөрсдийн үндэстний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан үйлдвэрлэл, үйлчилгээг зохиогчийн эрх, инновацид тулгуурлан, бизнес, хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр олон улсын болон үндэсний зах зээлд соёлын үйлдвэрлэлийг өргөжүүлэн, түүний эдийн засаг, нийгэмд оруулах бодит үр өгөөжийг нь хүлээн зөвшөөрч, улам бүр дэмжин хөгжүүлэх зорилт тавин хэрэгжүүлж байна.

Өвөрхангай аймгийн хувьд үндэсний болон орон нутгийнхаа арвин баялаг өв уламжлал, ёс заншил, соёлын онцлог, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлөөг сэргээх, хайрлан хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, олон нийтэд таниулах, сурталчлах арга хэмжээ авч, өөрийн нөөц, бололцоонд тулгуурлан соёлын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан “Соёлын үйлдвэрлэл” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

“Соёлын үйлдвэрлэл” аймгийн дэд хөтөлбөрийг дараах хүрээнд хэрэгжүүлнэ:

- дүрслэх урлаг (гар урлал, уран зураг);
- тайзны уран бүтээл (урлагийн тодорхой төрлийн тоглолт, үзүүлбэр);
- соёлын өв, уламжлал, зан заншил, соёлын аялал жуулчлал.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Үндэсний болон орон нутгийн соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар Монгол соёлын нөлөөг аймаг, бүс, улсын хэмжээнд нийтэд сурталчлан таниулахад оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

2.2.1 Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг, чадавхижуулах;

2.2.2 Мэргэжлийн болон соёлын өв уламжлал, зан заншлыг сурталчлах, соёлын бусад үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлэх, соёл, урлагийн үйлчилгээг зах зээлд гаргах:

2.2.3 Орон нутгийн брэнд үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх:

Гурав. Хөтөлбөрийн зарчим, аргачлал

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална

3.1.1 Хөтөлбөр нь орон нутаг, соёл урлагийн байгууллагуудын хүртээмж, оролцоог хангасан, тухайн сум, орон нутаг, соёл, урлагийн байгууллагад үр өгөөжтэй байх

3.1.2 Хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тухайн орон нутаг, байгууллага хариуцах

3.1.3 Тухайн орон, нутаг байгууллагын санаачилсан үйлчилгээ, соёлын үйлдвэрлэл нь давтагдахгүй, онцлогоо хадгалах

3.2. Хөтөлбөрийг дараах аргачлалаар хэрэгжүүлнэ

3.2.1. Мэргэжлийн болон ардын, уламжлалт ёс заншил, соёл урлагийн унаган төрхийг хамгаалан аялал жуулчлалтай хослуулах

3.2.2. Зорилго, зохион байгуулалт нэг чиглэлийн уралдаан наадам, тэмцээн бусад арга хэмжээг нэгтгэх, зарим тохиолдолд 2 жилд 1 удаа байхаар зохион байгуулах

3.2.3. Шаардлагатай тохиолдолд гадаад, дотоодын байгууллага, аж ахуй нэгжүүд харилцан хоорондоо үйл ажиллагааг хэрэгжүүлэх санамж бичиг байгуулах, гарын авлага сурталчилгааны материалыг англи хэлээр хэвлүүлэх

3.2.4 Төр, хувийн хэвшлийн түншлэл, олон нийтийн оролцоог хангасан байх;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг, чадавхижуулах зорилтын хүрээнд:

4.1.1. Соёл, урлагийн шилдэг бүтээлийг зохиогчийн эрхээр баталгаажуулах, санал санаачилгыг дэмжих

4.1.2. Соёлын үйлдвэрлэлийн асуудлыг хариуцан ажиллах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгож, ажлын байрны тодорхойлолтод нь энэ талаар тусгах

4.1.3. Соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр аймгийн болон орон нутгийн семинар, сургалт зохион байгуулах

4.1.4. Монголын болон гадаадын уран бүтээлчдийн харилцан туршлага солилцох, хамтран ажиллах, суралцах арга хэмжээг зохион байгуулах

4.2. Мэргэжлийн болон соёлын өв уламжлал, зан заншлыг сурталчлах, соёлын бусад үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлэх, соёл, урлагийн үйлчилгээг зах зээлд гаргах зорилтын хүрээнд:

4.2.1. Мэргэжлийн урлаг, ардын зан заншил, соёл уламжлалыг аялал жуулчлалтай хослуулсан төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

4.2.2. Сум бүр үндэсний өв уламжлал, зан заншил онцлогийг тусгасан брэнд үйл ажиллагааг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх ажлыг зохион байгуулах

4.2.3. Монголын болон гадаадын уран бүтээлчдийн харилцан туршлага солилцох, хамтран ажиллах, суралцах арга хэмжээг зохион байгуулах;

4.3. Орон нутгийн брэнд үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1. Сум бүр орон нутгийн нөөц бололцоо, онцлогийг тусгасан брэнд үйл ажиллагааг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх ажлыг зохион байгуулах

4.3.2. Дээрх брэнд үйл ажиллагааг үйлдвэрлэл, зах зээлд борлуулах ажлыг дэмжих, зохион байгуулах

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, түүний зохион байгуулалт, тайлан мэдээ, мэдээллийг гаргах, сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах чиг үүргийг аймгийн хэмжээний салбарын байгууллагуудын оролцоотойгоор аймгийн Засаг даргын тамгын газар, Засаг даргын дэргэдэх

Боловсрол, соёл, урлагийн газар нэгтгэн чиглүүлж, орон нутгийн түвшинд сумын Засаг даргын тамгын газар, Соёл, урлагийн байгууллага тус тус хариуцан гүйцэтгэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

6.1.2. Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламж

6.1.3. Аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

6.1.4. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

6.1.5. Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

7.1. Хөтөлбөрийг 2020 он хүртэл хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

7.1.1. Нэгдүгээр үе шат (2017–2018 он) -д үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

7.1.2. Хоёрдугаар үе шат (2018-2020 он) -д соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх соёл, урлагийн салбарын өрсөлдөх чадвар, бүтээлч хандлагыг төлөвшүүлэх, орон нутаг, үндэсний брэнд бүтээгдэхүүнээр зах зээлд танигдахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ

8.1.1. Соёлын үйлдвэрлэлийн мэдээлэл, судалгааны нэгдсэн бааз соёл, урлагийн салбарын статистик мэдээлэл шинээр бий болсон байх

8.1.2. Соёлын үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын тоо нэмэгдсэн байх /25% -иар/

8.1.3. Мэргэжлийн сургалтын чанар, сургалт – судалгаа - үйлдвэрлэлийн уялдаа, салбарын хүний нөөцийн чадавхи сайжирсан байдал, мэргэжил дээшлүүлсэн хүний тоо / 207 соёл, урлагийн ажилтан /

8.1.4. Оюуны өмч, зохиогчийн эрх авсан үйл ажиллагаа, бүтээлийн тоо, улсын хэмжээнд баталгаажсан бүртгэл

8.1.5. Соёл, урлагийн байгууллагын бие даан тогтвортой хөгжих чадавхи бүрдсэн байдал

8.1.6. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр гадаад улстай хамтран зохион байгуулсан байна. / жилд 2-оос доошгүй гадаад арга хэмжээ/

8.1.7. Аялал жуулчлалын салбар дахь соёлын аялал жуулчлалын өсөлт /жуулчдын тоо 45,000-аас 60,000 хүрнэ./

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг орон нутгийн соёл урлагийн байгууллагууд жил бүрийн I, III улиралд багтаан аймгийн ЗДТГазар болон БСУГазарт бичгээр ирүүлж байна. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг аймгийн ЗДТГазар, БСУГазар жил бүрийн I, III улиралд багтаан нэгтгэж БСШУСЯаманд хүргүүлж байх

---oo0oo---

“СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Үр дүн	Төсөв хариуцах газар
Хөтөлбөрийн зорилт: 2.2.1 Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг чадавхижуулах							
1.	Уран бүтээл бусад соёлын бүтээлийг зохиогчийн эрхэд бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	БСУГ ХДТ Соёлын байгууллагууд	Аймгийн ЗДТГ	Оюуны өмчийн газарт зохиогчийн эрх, оюуны өмчийг бүртгүүлсэн тоогоор	Оюуны өмчийн эрх хамгаалагдана.	ХДТ
2.	Соёл, урлагийн ажилтнуудыг чадавхижуулах орон нутгийн сургалт зохион байгуулах	Хөтөлбөрийн хугацаанд	БСУГ газар	Аймгийн ЗДТГ	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	Соёлын ажилтны ур чадвар, чадавхи сайжирна.	Орон нутгаас
3.	Соёлын үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулах, маркетинг, менежментийн сургалтыг зохион байгуулах	Хөтөлбөрийн хугацаанд	БСУГ	Соёл, урлагийн Төрийн бус байгууллага	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүний нөөц чадавхиар.	Орон нутгаас
4.	Өвөрхангай аймгийн “Урчуудын эвлэл”-ийн үйл ажиллагааг дэмжиж тэдэнтэй хамтран ажиллах	Хөтөлбөрийн хугацаанд	БСУГ, Аймгийн музей	Өвөрхангай аймгийн музей	Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, чанар	Өвөрхангай аймгийн соёлын үйлдвэрлэл хөгжинө.	Орон нутаг, оролцогчдын зардлаар
Хөтөлбөрийн зорилт 2.2.2 Мэргэжлийн болон соёлын өв уламжлал, зан заншлыг сурталчлах соёлын бусад үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлэх, соёл, урлагийн үйлчилгээг зах зээлд гаргах							

1.	Торгоны зам-Хархорин Эвент арга хэмжээний төслийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хугацаанд Жил бүрийн 7 дугаар сарын 14-19 ний хооронд	Аймгийн ЗДТГ БСУГ, ХДТ	Төслийг санхүүжүүлэгч байгууллага Бат-Өлзий, Бүрд, Хужирт сумдын ЗДТГ	Эвент арга хэмжээнд оролцогчдын тоогоор	Соёл, урлагийн аялал жуулчлал хөгжинө.	Хөтөлбөрийн санхүүжилтээр
2.	“Бидний авьяас, бидний бахархал” үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	БСУГ, Гучин-Ус, Хайрхандулаан сумын соёлын төв, бусад байгууллагууд	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ Бусад байгууллага	Арга хэмжээг үзсэн үзэгчдийн тоогоор	Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан урлагийн арга хэмжээг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Соёлын байгууллагууд хамтран санхүүжилтийг шийдвэрлэх
3.	Бүрд сум: Монгол адууны соёлыг уламжлуулан хөгжүүлэх, Орон нутаг судлах танхимаа аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх	Жил бүр Хөтөлбөрийн хугацаанд	Бүрд сумын ЗДТГ, Соёлын төв	БСУГ, БОАЖГ	Адууны баярт оролцогчдын тоо, ОНС танхимаар үйлчлүүлсэн жуулчдын тоо	Адууны соёл, өвлөгдөн уламжлагдана. ОНС танхимаар дамжуулан өв соёлоо сурталчилж, эдийн засгийн эргэлтэд оруулна.	БСУГ, БОАЖГ Бүрд сумын ЗДТГ,
4	Богд сум: Тэмээний баяр, тэмээний соёлын үйл ажиллагаа	Хөтөлбөрийн хугацаанд	Богд сумын ЗДТГ	БСУГ, БОАЖГ Аймгийн музей	Баярын үйл ажиллагаанд хамрагсдын тоогоор	Тэмээний соёлын уламжлалт зан үйл хөгжинө.	Богд сумын ЗДТГ, Соёлын төв
5.	Бат-Өлзий сум: Сарлагийн поло арга хэмжээнд соёл, урлагийн оролцоог нэмэгдүүлэх, Хүрхрээний дэргэд задгай тайзтай болж соёл, урлагийн аялал жуулчлалыг хөгжүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	Бат-Өлзий сумын ЗДТГ	БСУГ, БОАЖГ, Сумдын Соёлын төвүүд	Арга хэмжээнд оролцогчдын тоо,	Соёл, урлагийн аялал жуулчлал орон нутагт хөгжинө.	Бат-Өлзий сумын ЗДТГазар
6.	Мод эрээлэх уламжлалыг сурталчлан, өвлүүлэн	Хөтөлбөрийн	Бат-Өлзий	БСУГ	Сургалтад	Эрээлэх өв	Бат-Өлзий

	уламжлуулах ажлыг зохион байгуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих	хугацаанд	сумын ЗДТГ	Аймгийн урчуудын эвлэл	хамрагдаж, бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлсэн хүний тоогоор	уламжлагдана.	сумын ЗДТГ, Соёлын төв
7.	Баян-Өндөр сум: Шагайн наадгайн соёлыг өвлүүлэн уламжлуулах	Хөтөлбөрийн хугацаанд	Баян-Өндөр сумын соёлын төв	БСУГ	Шагайн наадгайн соёл өвлөгчдийн тоо	Шагайн наадгайн соёл өвлөгдөн уламжлагдана.	Баян-Өндөр сумын ЗДТГ
8.	Тарагт сум: Орон нутаг судлах танхимаа соёлын өв сурталчлах мэдээллийн төв болгох	Хөтөлбөрийн хугацаанд	Тарагт сумын ЗДТГ	Аймгийн музей, БСУГ	Музейн үзүүлэг дэглэлтийн чанараар	Соёл,урлагийн аялал жуулчлал орон нутагт хөгжинө.	Тарагт сумын ЗДТГазар
9.	Нарийнтээл сум: Нутгийн онцлогтой дууны "Бурхадын шуранхайтай нутаг" уралдааныг зохион байгуулах	2 жил тутам	Нарийнтээл сумын ЗДТГ	Аймгийн БСУГ, соёлын төвүүд	Уралдаанд оролцогчдын тоогоор	Шарга нутгийн дууны өв санг хадгалан өвлүүлэн уламжлуулна	Нарийнтээл сумын ЗДТГазар
10.	Уянга сум: Уянгын эрэн модон бүтээгдэхүүнийг сурталчлан, өвлүүлэн уламжлуулах ажлыг зохион байгуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих	Хөтөлбөрийн хугацаанд	Уянга сумын ЗДТГ	БСУГ Аймгийн урчуудын эвлэл	Сургалтад хамрагдаж, бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлсэн хүний тоогоор	Уянгын эрээлэх өв уламжлагдана.	Уянга сумын ЗДТГ, Соёлын төв
11.	Өлзийт сум: "Аравдах" монгол наадгайг уламжлуулан авч үлдэх	Хөтөлбөрийн хугацаанд	Өлзийт сумын ЗДТГ	БСУГ, БОАЖГ, Сумдын төвүүд	Арга хэмжээнд оролцогчдын тоо,	Соёл,урлагийн аялал жуулчлал орон нутагт хөгжинө.	Өлзийт сумын ЗДТГазар
12.	Өлзийт сум: Дөмөн Дулмаагийн нэрэмжит уртын дууны уралдаан	Хөтөлбөрийн хугацаанд	Өлзийт сумын ЗДТГ	БСУГ, БОАЖГ, Соёлын төвүүд	Арга хэмжээнд оролцогчдын тоо,	Соёл,урлагийн аялал жуулчлал орон нутагт хөгжинө.	Өлзийт сумын ЗДТГазар
13.	Баруун баян-Улаан сум: Сайн ноён хошууны дууч хуурч Янгивын нэрэмжит морин хуурчдын бүсийн уралдаан зохион байгуулах	Хөтөлбөрийн хугацаанд	Баруунбаян-Улаан сумын ЗДТГ	БСУГ ББУ сумын ЗДТГ, Соёлын төвүүд	Уралдаанд оролцогчдын тоогоор	Морин хуурын өвлөн уламжлагчид	Баруунбаян-Улаан сумын ЗДТГ

Хөтөлбөрийн зорилт 2.2.3. Орон нутгийн Брэнд соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих хөгжүүлэх чиглэлээр:

1.	Хужирт сум: МУУГЗ Бямбабаярын нэрэмжит аймгийн нийтийн дууны уралдааныг зохион байгуулах	2 жил тутам	Хужирт сумын ЗДТГ, Соёлын төв	Аймгийн Засаг даргын дэргэдэх БСУГ, Аймгийн ХДТ, Сумдын Соёлын төвүүд	Нийтийн дууны уралдаанд оролцогчдын тоо	Хүүхэд залуучуудын авьяас, ур чадвар дээшилж, гавьяатыг уран бүтээлийг нийтийн хүртээл болгох	Хужирт сумын ЗДТГ
2	Хужирт сумаас төрж гарсан зохиолч, яруу найрагчдын чуулганыг зохион байгуулах	Жил бүр	Хужирт сумын ЗДТГ, Соёлын төв	Хужирт сумын ЗДТГ	Чуулганд оролцогчдын тоо	Шүлэг яруу найраг сонирхогчид, бичигчдийн тоо нэмэгдэнэ.	Хужирт сумын ЗДТГ
3.	Арвайхээр сум: Жил бүрийг 06-р сарын 01 нд "Номын үзэсгэлэн худалдаа, ном солилцоо ном сурталчлах, гэрэл зураг сонирхогчдын өдөрлөг"-ийг зохион байгуулах	Жил бүр	Арвайхээр сумын ЗДТГ, Аймгийн Төв номын сан	Аймгийн Засаг даргын дэргэдэх БСУГ	Арга хэмжээнд оролцогчдын тоогоор	Ном унших, түүнийг сонирхох уншигчдын тоо өснө. Гэрэл зураг сонирхогчдын тоо өснө.	Арвайхээр сумын ЗДТГ
4.	Баян-Өндөр сум: Хүүхдийн жүжгийг хөгжүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	Баян-Өндөр сумын соёлын төв	Аймгийн Засаг даргын дэргэдэх БСУГ	Жүжгийн дугуйланд оролцогчдын тоогоор	Хүүхэд залуучуудын авьяас, ур чадвар дээшилж	Баян-Өндөр сумын ЗДТГ
5.	Баянгол сум: Домог ардын дууны наадмыг зохион байгуулах, уламжлуулж, хөгжүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	Баянгол сумын ЗДТГ, Соёлын төв	БСУГ, ХДТ, Соёлын төвүүд	Уралдаанд оролцогчдын тоо	Ардын домогт дууны өв уламжлагдана.	Баянгол сумын ЗДТГ
6.	Есөнзүйл сум: Уран уншлагын наадмыг зохион байгуулж	Хөтөлбөрийн хугацаанд	Есөнзүйл сумын ЗДТГ, Соёлын төв	БСУГ, ХДТ, Соёлын төвүүд	Уралдаанд оролцогчдын тоо	Хүүхэд залуучуудын авьяас хөгжинө.	Есөнзүйл сумын ЗДТГ, Соёлын төв

	хөгжүүлэх						
7.	Гучин Ус сум: Хүүхдийн мюзикл жүжгийг хөгжүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	Гучин-Ус сумын ЗДТГ, Соёлын төв	БСУГ, ХДТ, Сумдын Соёлын төвүүд	Жүжгийн тоо, жүжигт ороцсон хүүхдийн тоо	Хүүхэд залуучуудын авьяас хөгжинө.	Гучин-Ус сумын ЗДТГ, Соёлын төв
8.	Гучин Ус сум: Д.Галсанбатын нэрэмжит Эстрадын дуучдын уралдаан	2 жилд 1 удаа	Аймгийн ЗДТГ, Гучин-Ус сумын ЗДТГ, Соёлын төв	Аймгийн ЗДТГ, БСУГ, Гучин-Ус сумын ЗДТГ, Соёлын төв	Уралдаанд оролцогч аймгууд, оролцогчдын тоо	Орон нутагт эстрадын урлаг хөгжинө.	Аймгийн ЗДТГ, Гучин-Ус сумын ЗДТГ
9.	Сант сум: Хослон дуулахын жаргал Хос дуэт дууны уралдаан	2 жилд 1 удаа	Сант сумын ЗДТГ, Соёлын төв	БСУГ, Аймгийн ХДТ, Сумдын Соёлын төвүүд	Уралдаанд оролцогчдын тоо	Хүүхэд залуучуудын авьяас хөгжинө.	Сант сумын ЗДТГ, Соёлын төв
10.	Зүүнбаян-Улаан сум: Спорт бүжгийг хөгжүүлэх	Хөтөлбөрийн хугацаанд	Зүүнбаян-Улаан сумын Соёлын төв	БСУГ, Сумдын Соёлын төвүүд	Бүжгээр хичээллэж буй хүний тоо	Орон нутагт спорт бүжиг хөгжинө.	Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ, Соёлын төв
11.	Хайрхандулаан сум: Эх орон танаа цэргийн дууны уралдаан	Хөтөлбөрийн хугацаанд	Хайрхандулаан сумын ЗДТГ, Соёлын төв	БСУГ, Сумдын Соёлын төвүүд	Уралдаанд оролцогчдын тоо	Хүүхэд залуучуудын авьяас чадвар хөгжинө	Хайрхандулаан сумын ЗДТГ, Соёлын төв
12.	Төгрөг сум: Утга зохиолын өдөр, уншигч зохиогчийн уулзалт, яруу найргийн өдөрлөгийг хөгжүүлэх,	Хөтөлбөрийн хугацаанд	Төгрөг сумын ЗДТГ	Аймгийн БСУГ, Үндэсний номын сан, Монголын Зохиолчдын эвлэл	Оролцогчдын тоогоор	Утга зохиол, яруу найраг хөгжиж кино сохирхогчид нэмэгдэнэ.	Төгрөг сумын ЗДТГазар